

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН  
РЕКТОР Б.ОЧИРХУЯГ ТАНАА

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
15-р хороо, 13-р хороолол,  
Энхтайваны өргөн чөлөө,  
49-р барилга, Соманг плаза,  
4-р давхар, Шуудангийн хайрцаг 705,  
Улаанбаатар 13370

Утас: 976 70155323

Э-мэйл: mongolia@wvi.org  
Вэбсайт: <https://www.worldvision.mn>

2024.10.22

№ 267/24

Улаанбаатар хот

Хамтран ажиллах тухай

Нэгдсэн Үндэсний Байгууллагын санаачилгаар дэлхий даяар жорлонгийн өдрийг энэ жил “Жорлон бол бидний амар тайван орчин” гэсэн нэгдсэн сэдвийн дор тэмдэглэх бөгөөд Дэлхийн Зөн Монгол ОУБ нь бусад байгууллагуудтай хамтран нөлөөллийн нэг жилийн аяныг эхлүүлэхээр ажиллаж байна.

Тус аяны хүрээнд 15-22 насны хүүхэд, оюутан залуусын оролцоотойгоор, нүхэн жорлонгийн хэрэглээнээс үүдэх орчны бохирдлыг бууруулах, хүн амыг болзошгүй эрсдэлээс сэргийлэх, шийдэл олох, шийдвэр гаргагчдад дуу хоолойгоо хүргэх зорилго бүхий төслийн болон видео контентын тэмцээн зохион байгуулна.

2024 оны 11 дүгээр сарын 19-ний дэлхийн жорлонгийн өдрийг тохиолдуулан аяны нээлтийг МУИС-ийн Төв номын сангийн танхимд 120 гаруй хүүхэд, оюутан залуучуудыг хамруулан зохион байгуулахаар төлөвлөж байна.

Нээлтийн арга хэмжээг зохион байгуулах ажлыг дэмжин тус сургуулийг төлөөлөн нийгмийн эрүүл мэнд, маркетинг, инженер, социологи, байгаль орчны чиглэлээр суралцдаг 5-аас 8-н оюутан залуучуудыг багш, нийгмийн ажилтны хамтаар оролцохыг урьж байна.

Мөн энэхүү нөлөөллийн аян болон “Дэлхийн жорлонгийн өдөр”-ийг тэмдэглэх үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг Санчирмаа 96892909, Мөнх-Эрдэнэ 94947740 дугаараар холбогдоно уу.

Хамтран ажиллах тухай албан хариу болон оюутнуудын мэдээлэлийг 10-р сарын 28-ны дотор бидэнд мэдэгдэнэ үү.

(2024 оны 11 сарын 19-ний өдөр хийх нээлтийн хөтөлбөрийг хавсаргав)

Хүндэтгэсэн,

ДЭЛХИЙН ЗӨН МОНГОЛ ОУБ-ЫН  
ҮНДЭСНИЙ ЗАХИРАЛ



Б.БОЛОРЦЭЦЭГ

**“ЖОРЛОН БОЛ АМАР ТАЙВАН ОРЧИН”  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

2024.10.22

Улаанбаатар хот

**Зорилго:** Дэлхийн Жорлонгийн Өдрийг тохиолдуулан нүхэн жорлонгийн хор уршгийн талаарх олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх, ариун цэврийн байгууламжийн талаар зөв хандлага, дадал зуршлыг сурталчилж, жорлонгийн асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах.

**Хэзээ:** 2024 оны 11-р сарын 19-ний өдрийн 14.00-17.00 цагт

**Хаана:** МУИС-ийн төв номын сангийн байр, 5 давхарт 502 тоот

**Хөтөлбөр:**

Цаг	Үйл ажиллагаа
14:00-14:30	Бүртгэл & Кофе
14:30-14:40	Нээлтийн үг <ul style="list-style-type: none"><li>МУ-ын ЗГХА, Усны газар</li><li>ДЗМОУБ</li></ul>
14:40-14:50	УБ хотын байгаль орчны (хөрс, ус) нөхцөл байдал: <ul style="list-style-type: none"><li>НЭМҮТ</li></ul>
14:50-15:00	Нүхэн жорлонгийн нөхцөл байдлын талаар мэдээлэл өгөх <ul style="list-style-type: none"><li>Монголын жорлонгийн холбоо ТББ</li></ul>
15:00-15:10	Жорлонгийн асуудал - олон улсад /видео/ <ul style="list-style-type: none"><li>Жак Сим, Дэлхийн Жорлонгийн Байгууллагыг үүсгэн байгуулагч</li></ul>
15:10-15:20	Их дээд сургууль, ЕБС-ийн оюутнуудын дунд "Цэвэр, эрүүл маргаашийн төлөө" тэмцээний зарлал <ul style="list-style-type: none"><li>Видео контент</li><li>Шилдэг шийдэл/төсөл/</li></ul>
15:20-15:40	Нээлттэй микрофон <ul style="list-style-type: none"><li>Оролцогч байгууллагууд</li><li>Оюутан, сурагчид</li></ul>
15:40-15:50	Зураг авах цаг
15:50-16:50	Ус орчин, ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжийн тухай болон төсөл хөтөлбөрүүдийн мэдээллийг багтаасан ханан илтгэлээр зочлох <ul style="list-style-type: none"><li>НЭМҮТ</li><li>Усны газар</li><li>НҮБ-ын Хүүхдийн сан</li><li>МУЗН</li><li>“Монголын жорлонгийн холбоо” ТББ</li><li>“Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн дэвшлийн төв” ТББ</li><li>ДЗМОУБ болон бусад</li></ul>
16:50-17:00	Хаалтын үг